

Шагналын журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Дундговь аймгийн Засаг даргын шагнал олгох журам”- ыг 1 дүгээр хавсралтаар, “Урамшууллын жишиг тогтоох журам”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Дээрх журмуудыг байгууллага, иргэдэд сурталчлан хэрэгжүүлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, иргэдийн урлаг, спортын авьяасыг нээн илрүүлэх, сурагч, багш нарын оюуны хөдөлмөрийг бодитой дээшлүүлэх, тэдний ур чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг бүх талаар дэмжин, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар /О.Чулуунбат/, журамд заасан шагналд олгох мөнгөн хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж байхыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /А.Ганбат/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү журам гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/565 дугаар захирамж, Засаг даргын 2015 оны 09 сарын 18-ны өдрийн “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/370 тоот захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь аймгийн Засаг даргын шагналыг тодорхойлох, дээрх шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлэх, уламжлах, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулах, шагналын тэмдэг, тэдгээрийн үнэмлэхийг нөхөн болон сольж олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Шагналын нэр, төрөл

1. Аймгийн Засаг даргын шагналд /цаашид Засаг даргын шагнал гэх/ дараах шагналууд хамаарна.
 - 1.1. Аймгийн “Хүндэт иргэн” цол, тэмдэг
 - 1.2. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээ
 - 1.3. Аймгийн “Тэргүүний ажилтан” үнэмлэх, тэмдэг
 - 1.4. Аймгийн “Аварга малчин” үнэмлэх, тэмдэг
 - 1.5. Аймгийн “Тэргүүний тариаланч” үнэмлэх, тэмдэг
 - 1.6. Аймгийн “Аварга саальчин” үнэмлэх, тэмдэг
 - 1.7. Аймгийн “Тэргүүний хамт олон” өргөмжлөл
 - 1.8. Аймгийн “Хүндэт тэмдэг” үнэмлэх
 - 1.9. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”
 - 1.10. Аймгийн “Алдарт уяач” цол, тэмдэг
 - 1.11. Аймгийн “Алдарт морин хуурч” цол, өргөмжлөл
 - 1.12. Аймгийн “Алдарт уртын дууч” цол, өргөмжлөл
 - 1.13. Аймгийн “Оюунлаг залуу” цом, тэмдэг
 - 1.14. Аймгийн “Тэргүүний сурагч” өргөмжлөл
2. Засаг даргын шагналыг жил бүр олгох бөгөөд нэг төрлийн шагналаар дахин шагнахгүй.
3. Тэргүүний хамт олон, ажилтан, аварга малчнаар шалгарч шагнагдсан иргэний гэрэл зургийг аймгийн Засаг даргын Тамгын газрын “Оны алдартан” самбарт тавьж алдаршуулна.

Гурав. Шагнал олгох болзол

1. Аймгийн “Хүндэт иргэн” цол тэмдгээр аймгийн хөгжил цэцэглэлтэнд үнэтэй хувь нэмэр оруулан, нутаг орныхоо алдар гавъяаг улс, олон улсын хэмжээнд дуурсгаж яваа олонд танигдсан нэр хүнд бүхий иргэнийг шагнаж урамшуулна.
2. Засаг даргын шагналаар аймаг, сумыг хөгжүүлэх, байгууллагын эрхэм, зорилго, зорилтыг ханган биелүүлэх, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж, хөдөлмөрийн тогтвортой амжилт гаргасан, нэр хүндтэй, үнэнч шударга, ёс зүйт иргэн, хамт олныг шагнаж урамшуулна.
3. Засаг даргын шагналаар шагнахад ажил, хөдөлмөрийн үр дүнгээрээ тухайн сумын Засаг даргын шагналаар эсвэл салбарын шагналаар эсвэл байгууллагынхаа тэргүүний ажилтнаар шагнагдсан иргэнийг шагнах бөгөөд аймгийн Засаг даргын шагналын дарааллыг баримтална. Аймагт ажлаа тайлагнадаг байгууллагад сумын шагнал хамаарахгүй.

4. Засаг даргын шагналаар улсад 5-аас доошгүй жил ажилласан, өмнөх шагналыг авснаас хойш 2-аас доошгүй жил ажиллаж, хөдөлмөрийн амжилт гаргасан байна.
5. Аймгийн “Аварга малчин”, аймгийн “Тэргүүний тариаланч”, аймгийн “Аварга саальчин” шагналыг тусгай журмын дагуу олгоно.
6. Аймгийн “Тэргүүний сурагч” өргөмжлөлөөр сурлага, урлаг, спортоор бусдыгаа хошуучлан үлгэр дууриал үзүүлсэн Ерөнхий боловсролын сургуулийн тэргүүний сурагчийг шагнаж урамшуулна.
7. Орон нутгийг хөгжүүлэхэд идэвх зүтгэл үр бүтээлтэй оролцож бодитой хувь нэмэр оруулсан гаднын байгууллага, хамт олон, иргэн түүнчлэн гадаадын иргэнийг шагнаж болно.

Дөрөв. Засаг даргын шагналд нэр дэвшүүлэх, өргөн мэдүүлэх, түүнийг хүлээн авч судлах, шийдвэрлэх, шагналыг гардуулах

1. Засаг даргын шагналаар шагнуулах санаачилгыг төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж болон албан байгууллагаас гаргаж болно.
2. Анхан шатны байгууллага шагнуулах хүний ажил байдлын тодорхойлолт, шагнуулах гэж байгаа үндэслэл, хөдөлмөрийн үр дүн, байгуулсан гавъяаг тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв гаргаж, шагнуулах тухай тодорхойлолт, хамт олны хурлын тэмдэглэл, ажлын үр дүнг харуулсан судалгаа, тоо баримтын хамт бүрдүүлнэ.
3. Шагнуулах хүний тодорхойлолт нь доорх материалаас бүрдэнэ.
 - а. Ажил байдлын тодорхойлолт /Энэ журмын хавсралт/
 - б. Хамт олны хурлын тэмдэглэл
 - в. Харьяалах байгууллагын даргын буюу сумын Засаг даргын дүгнэлт
4. Анхан шатнаас гаргасан санаачилгыг тухайн хүний ажиллаж байгаа байгууллагын удирдлага судалж, хамт олны хурлаар хэлэлцүүлэн саналыг сумын Засаг даргаар дүгнэлт гаргуулж аймгийн харъяалах дээд байгууллагад ирүүлнэ.
5. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагууд шагнуулах саналаа аймгийн Засаг даргын Тамгын газрын харъяалах хэлтсүүдэд ирүүлнэ.
6. Тамгын газрын хэлтсүүд нь харъяалах байгууллагаас ирүүлсэн шагналын материалыг хянаж, шагнуулах саналтай бол дүгнэлтийн хамт асуудлыг аймгийн Засаг даргад танилцуулан шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст материалыг шилжүүлнэ.
7. Засаг даргын шагналыг харъяалах хэлтсийн даргын саналыг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс нэгтгэн хяналт тавьж, бүртгэн, шийдвэрийг эцэслэн гаргаж, шагнал гардуулах ажлыг зохион байгуулна.
8. Сум, байгууллагаас ирүүлсэн тодорхойлолтуудыг ЗДТГ-ын хэлтэс бүр дээр бүртгэж, хэрхэн шийдвэрлэсэн талаар тухайн тодорхойлсон газарт ажлын 10 хоногт албан ёсоор бичгээр хариу өгч байна.
9. Шагналд олгох мөнгөн шагналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гаргана.

Тав. Аймгийн болон Засаг даргын шагналыг дагалдах мөнгөн шагналын хэмжээ

1. Аймгийн “Хүндэт иргэн” цол, тэмдэг олгоход 200.000 /хоёр зуун мянга/ төгрөг
2. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээ олгоход 150.000 /нэг зуун тавин мянга/ төгрөг

3. Аймгийн “Тэргүүний ажилтан” тэмдэг олгоход 100.000 /нэг зуун мянга/ төгрөг
4. Аймгийн “Аварга малчин” тэмдэг олгоход тусгай журмын дагуу
5. Аймгийн “Тэргүүний тариаланч” тэмдэг олгоход тусгай журмын дагуу
6. Аймгийн “Аварга саальчин” тэмдэг олгоход тусгай журмын дагуу
7. Аймгийн “Тэргүүний хамт олон” өргөмжлөл олгоход 300.000 /гурван зуун мянга/ төгрөг
8. Аймгийн “Хүндэт тэмдэг” олгоход аймгийн баяр наадам, улс тунхагласны баяр, цагаан сарын баярын үеэр зохиогдох урлаг, спортын арга хэмжээнд үнэгүй үйлчлүүлэх эрх
9. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг” олгоход 10.000 /арван мянга/ төгрөг байх ба дагалдах мөнгөн шагналыг тухайн хүнийг тодорхойлсон байгууллага гаргана.
10. Аймгийн “Алдарт уяач” цол, тэмдэг олгоход холбогдох хууль тогтоомжийн дагуу
11. Аймгийн “Алдарт морин хуурч”, “Алдарт уртын дууч” цол, өргөмжлөл олгоход медалион
12. Аймгийн “Оюунлаг залуу” үнэмлэх, цом олгож алдаршуулна.
13. Аймгийн “Тэргүүний сурагч” Өргөмжлөл олгоход 50.000 /тавин мянга/ төгрөг

Дөрөв. Аймгийн болон Засаг даргын шагналаар жил бүр шагнах хүний тоо

1. Аймгийн “Хүндэт иргэн” цол, тэмдэгээр –шаардлагатай үед
2. Аймгийн “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээгээр 3 хүртэл хүн
3. Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр жилийн эцсийн үнэлгээгээр 15 хүртэл хүн, бусад шаардлагатай үед
4. Аймгийн “Тэргүүний ажилтан” тэмдгээр 9 хүртэл хүн
5. Аймгийн “Аварга малчин” үнэмлэх, тэмдгээр 30 хүртэл хүн
6. Аймгийн “Тэргүүний тариаланч” өргөмжлөлөөр 1 хүртэл хүн
7. Аймгийн “Аварга саальчин” үнэмлэх, тэмдгээр 5 хүртэл хүн
8. Аймгийн “Тэргүүний хамт олон” өргөмжлөлөөр 3 хүртэл хамт олон
9. Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр жилийн эцсийн үнэлгээгээр 30 хүртэл хүн, бусад шаардлагатай үед
10. Аймгийн “Алдарт уяач” цол, тэмдэг – болзлын дагуу
11. Аймгийн “Алдарт морин хуурч”, “Алдарт уртын дууч”-цол, өргөмжлөл олгох хүний тоог тухайн үед нь шийдвэрлэнэ.
12. Аймгийн “Оюунлаг залуу” үнэмлэх, тэмдгээр -тухайн үед нь шийдвэрлэнэ.
13. Аймгийн “Тэргүүний сурагч” өргөмжлөлөөр тухайн үед нь шийдвэрлэнэ.

Тав. Шагнах хугацаа

1. Жилийн эцсийн ажлын үр дүнгийн үнэлгээгээр Засаг даргын шагналаар шагнах хүмүүсийг дараа оны 1-р сард шалгаруулж, Монголын цагаан сараар шагналыг гардуулна.
2. Аймаг, сум, байгууллагын түүхт ой, тэмдэглэлт баярыг тохиолдуулан тухайн байгууллагын албан хаагчдыг шагнаж урамшуулж болно.

Зургаа. Засаг даргын шагналыг тэмдэг үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

1. Засаг даргын шагналын тэмдэг, үнэмлэхийг ямар нэгэн шалтгаанаар үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах эгч, дүүд нь зохих үнээр нь нөхөн болон сольж олгож болно.
2. Засаг даргын шагналын тэмдэг, үнэмлэхийг шагналын эзэн, түүний нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү нөхөн болон сольж авахыг хүсвэл

үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдлөө, үнийг банканд тушаасан баримт, эвдэрч гэмтсэн зүйлийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

3. Аймгийн Засаг даргын Тамгын газар өргөдлийг хянан үзэж, шагналын тэмдэг, үнэмлэхийг үндэслэлтэй гэж үзвэл Засаг даргын Тамгын газрын даргын тушаал гаргаж шийдвэрлэнэ.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШАГНАЛААР ШАГНУУЛАХ ХҮНИЙ
АЖИЛ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

1. Овог нэр
2. Регистрийн дугаар
3. Эрэгтэй, эмэгтэй
4. Боловсрол, мэргэжил
5. Үндсэн захиргаа
6. Хаана, хэзээ, ямар ажил эрхэлж байсан, одоо хаана ямар ажилтай
7. Төр, засгийн дээд ямар шагналаар хэзээ юуны учир шагнагдсан
8. Аймгийн болон салбарын ямар шагналаар хэзээ юуны учир шагнагдсан
9. Бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан
10. Шагнуулах гэж байгаа үндэслэл /Энэ хэсэгт тухайн хүний ажлын амжилт үр дүнг А4 хэмжээний цаасан дээр 2-оос илүүгүй хуудсанд багтаан бичиж сүүлийн 3-аас доошгүй жилийн ажлын үзүүлэлтийг хавсаргана./

ТОДОРХОЙЛСОН:

/Тамга, албан тушаал, гарын үсэг, нэр/

УРАМШУУЛЛЫН ЖИШИГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь иргэдийн оюуны чадавхи болон урлаг, спортын авьяасыг хөгжүүлэх, олон улс, улсын хэмжээнд урлаг, спорт, хөдөлмөрийн амжилт гаргасан уран бүтээлч, ардын авьяастан, тамирчид, мэргэжлийн албан хаагчид, өсвөр үеийнхний ур чадварын үнэлэмжийг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2 Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр зохион байгуулагдаж буй уралдаан, тэмцээн, наадмыг улсын хэмжээний уралдаан, тэмцээн, наадам гэж үзнэ.
- 1.3 Чиглэлийн ТББ-ууд болон аймгийн Засаг дарга нарын шийдвэрээр зохион байгуулагдаж буй уралдаан, тэмцээн, наадамд хамаарахгүй.
- 1.4 Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, олимп, тив, дэлхийн хэмжээний уралдаан, тэмцээн, наадам, олимпиадын төрөлд орсон, уралдаан, тэмцээн, наадмыг олон улсын чанартай уралдаан тэмцээн наадам гэнэ.
- 1.5 Олон улс, улсын чанартай боловсрол, соёл, урлаг, спортын олимп, олимпиад, уралдаан тэмцээн, наадамд амжилттай оролцон, эхний гурван байранд шалгарч, шагнал хүртсэн аймгийн харьяат иргэдийг энэхүү урамшуулалд хамруулна.
- 1.6 Тухайн нэг олимп, олимпиад, уралдаан тэмцээн, наадмын олон төрөлд оролцож амжилт үзүүлсэн багш, сурагч, тамирчин, дасгалжуулагч, уран бүтээлч, ардын авьяастанд хамгийн өндөр амжилтаар нь тооцож, урамшууллыг нэг удаа олгоно.
- 1.7 Ганцаарчилсан тоглолтоор медаль хүртсэн тамирчны дасгалжуулагчид тухайн тамирчинд олгосон мөнгөн шагналын 70 хувьтай, багийн тоглолтоор медаль хүртсэн тамирчдын дасгалжуулагчид нийт тамирчдын шагналын дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.
- 1.8 Багийн тоглолтоор медальт байранд шалгарвал багийн гишүүн тус бүрт ганцаарчилсан төрлөөр олгож буй шагналын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно.
- 1.9 Тив, дэлхийн чанартай олимп, олимпиад болон боловсрол, соёл, урлаг, спортын уралдаан, тэмцээн, наадам, олимпиадад амжилттай оролцож, эхний гурван байранд шалгарч шагнал хүртсэн аймгийн харьяат болон уугуул иргэдэд Засгийн газраас олгох шагналын 10 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг нэг удаа олгоно.
- 1.10 Урамшууллыг хүсэлт ирсэн тухайн үед нь судалж, тив, дэлхий, олон улс, улсын чанартай боловсрол, соёл, урлаг, спортын олимп, олимпиад, уралдаан тэмцээн, наадмыг зохион байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, удирдамж болон холбогдох байгууллагын тодорхойлолт бүхий хүсэлт, амжилт гаргаж авсан шагналыг нотлох баримт зэргийг үндэслэн журмын дагуу олгоно.
- 1.11 Улсын аварга, хошой аварга малчин, улсын аварга саальчин, улсын тэргүүний тариаланчаар шалгарсан тохиолдолд урамшуулал олгоно.

Хоёр. Монгол улсын төрийн дээд цол хүртсэн хүмүүст олгох мөнгөн урамшуулал (мян.төг)

2.1 Төрийн дээд шагнал хүртсэн, орон нутагтаа ажиллаж, амьдарч буй аймгийн харьяат иргэнд дараах урамшууллыг олгоно.

Төрийн дээд цол	Мөнгөн шагнал
Эрхэм дээд цол	
Баатар	2000.0
Хөдөлмөрийн баатар	1000.0
Хүндэт цол	
Ардын цолтон	700.0
Төрийн соёрхолт	600.0
Гавьяат цол	500.0

2.2 Төрийн дээд цол хүртсэн аймгийн уугуул иргэнд дараах урамшуулал олгоно.

Төрийн дээд цол	Мөнгөн шагнал
Эрхэм дээд цол	
Баатар	1500.0
Хөдөлмөрийн баатар	800.0
Хүндэт цол	
Ардын цолтон	600.0
Төрийн соёрхолт	500.0
Гавьяат цол	400.0

Гурав. Олон улсын болон улсын уралдаан, тэмцээнд оролцож амжилт гаргасан тамирчдад олгох урамшуулал

3.1 Үндэсний их баяр наадамд оролцож амжилт гаргасан бөх, уяач, сур, шагайн харваачдад олгох мөнгөн урамшуулал

3.1.1 Улсын цол хүртсэн бөхөд: (сая.төг)

Тэмцээний ангилал	Улсын аварга	Улсын арслан	Улсын гарьд	Улсын заан	Улсын харцага	Улсын начин
Улсын баяр наадам	Авто машин	6.0	5.0	4.0	3.0	2.0

3.1.2 Уяачдад: (мян.төг)

Тэмцээний ангилал	Түрүүлсэн	Аман хүзүүдсэн	Айргийн 3, 4, 5-д орсон
Улсын баяр наадам	500.0	300.0	200.0

3.1.3 Үндэсний сур харваачдад (мян.төг)

Тэмцээний ангилал	Алт /1-р байр/	Мөнгө /2-р байр/	Хүрэл /3-р байр/
Насанд хүрэгчид	1.000.0	800.0	500.0
Өсвөр үе	300.0	200.0	100.0

3.1.4 Шагайн харваачдад (мян.төг)

Тэмцээний ангилал	Алт /1-р байр/	Мөнгө /2-р байр/	Хүрэл /3-р байр/
Насанд хүрэгчид	800.0	500.0	300.0

3.2 Тамирчид, уран бүтээлчдэд олгох мөнгөн урамшуулал**3.2.1 Олон улсын чанартай наадам, уралдаан, тэмцээн (мян.төг)**

Тэмцээний ангилал	Алт /1-р байр/	Мөнгө /2-р байр/	Хүрэл /3-р байр/
Насанд хүрэгчдийн ангилалд	500.0	400.0	300.0
Өсвөр үеийн ангилалд	300.0	200.0	100.0

3.2.2 Улсын чанартай наадам, уралдаан, тэмцээн /мян.төг/

Наадам, уралдаан, тэмцээний ангилал	Алт /1-р байр/	Мөнгө /2-р байр/	Хүрэл /3-р байр/
Монголын бүх ард түмний урлагийн наадам, спартакиад,	200.0	150.0	100.0
Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах урлагийн уралдаан, наадам	150.0	100.0	70.0
Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах урлагийн уралдаан, наадам	100.0	80.0	60.0
Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах спортын уралдаан, тэмцээн	150.0	100.0	70.0
Өсвөр үеийн улсын аварга шалгаруулах спортын уралдаан, тэмцээн	100.0	80.0	60.0

Гурав. Олон улс болон улсын чанартай олимпиад, мэргэжлийн болон эрдэм шинжилгээний уралдаанд амжилт гаргасан иргэдэд олгох урамшуулал

3.1 Олон улсын олимпиад: (мян.төг)

Эзэлсэн байр	Сурагч	Аймгаас бэлтгэж оролцуулсан багш
Алт /1-р байр/	1000.0	400.0
Мөнгө /2-р байр/	800.0	300.0
Хүрэл /3-р байр/	600.0	200.0

3.2 Улсын олимпиад: (мян.төг)

Эзэлсэн байр	Сурагч	Аймгаас бэлтгэж оролцуулсан багш
Алт /1-р байр/	200.0	100.0
Мөнгө /2-р байр/	150.0	80.0
Хүрэл /3-р байр/	100.0	50.0

3.3. Мэргэжлийн “Ур чадвар”-ын уралдаан, “Эрдэм шинжилгээний илтгэл” –ийн улсын уралдаан болон олимпиадад амжилт үзүүлсэн насанд хүрэгчдэд олгох мөнгөн урамшуулал (мян.төг)

Эзэлсэн байр	Албан хаагчдад олгох мөнгөн урамшууллын хэмжээ
Улсын олимпиад	
Алт /1-р байр/	250.0
Мөнгө /2-р байр/	200.0
Хүрэл /3-р байр/	150.0
Ур чадварын уралдаан	
Алт /1-р байр/	200.0
Мөнгө /2-р байр/	150.0
Хүрэл /3-р байр/	100.0
Эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан	
Алт /1-р байр/	150.0
Мөнгө /2-р байр/	100.0
Хүрэл /3-р байр/	60.0

Дөрөв. Улсын Тэргүүний цол хүртсэн байгууллагад олгох мөнгөн урамшуулал (мян.төг)

Хүртсэн цол	Олгох урамшуулал
Улсын Тэргүүний байгууллага	Хүндэт өргөмжлөл 1.000.0 төгрөг

Тав. Улсын аварга, хошой аварга малчин, улсын аварга саальчин, улсын тэргүүний тариаланчаар шалгарсан малчид, саальчид тариаланчдад олгох урамшуулал (мян.төг)

Хүртсэн цол	Олгох урамшуулал
Улсын хошой аварга малчин	800,0 төгрөгийн дурсгалын зүйл
Улсын аварга малчин	500,0 төгрөгийн дурсгалын зүйл
Улсын аварга саальчин	500,0 төгрөгийн дурсгалын зүйл
Улсын тэргүүний саальчин	500,0 төгрөгийн дурсгалын зүйл

Улсын аварга малчин цол тэмдгээр шагнагдсан хүмүүсийн гэр бүлийн хүнийг аймгийн хүндэт тэмдгээр шагнаж урамшуулна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн А/251 тоот захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Урамшууллын жишиг тогтоох журам”-ын 1.2 дахь заалтыг “Монгол Улсын Засгийн газрын холбогдох яамд, түүний харьяа төрийн байгууллага, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд зарим чиг үүргээ чиглэлийн ТББ-уудаар гүйцэтгүүлэн, хамтран зохион байгуулсан болон тус байгууллагуудын шийдвэр, удирдамж, албан бичиг, баталсан хуваарийн дагуу зохион байгуулагдаж буй уралдаан, тэмцээн, наадмыг улсын хэмжээний уралдаан, тэмцээн, наадам” гэж, мөн 1.3 дахь заалтыг “Тус журмын 1.2-т зааснаас бусад тохиолдолд буюу чиглэлийн ТББ-ууд болон аймгийн Засаг дарга нарын шийдвэрээр зохион байгуулагдаж буй улсын уралдаан, тэмцээн, наадамд хамаарахгүй” гэж өөрчлөн найруулсугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ